

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Огноо: **2020 оны 03 дугаар сарын 17**

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 18 ДУГААР ХОРООНЫ БАЙРНЫ ЗООРИЙН ДАВХРЫГ
ТОХИЖУУЛАХ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН
БАРИМТ БИЧИГ**

Төслийн дугаар: **ХУД2020/ДТХ-04-41**

**Улаанбаатар хот
2020 он**

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2020 оны 03 дугаар сарын 17

Тендер шалгаруулалтын нэр: Хан-Уул дүүргийн 18 дугаар хорооны байрны зоорийн давхрыг тохижуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах

Тендер шалгаруулалтын дугаар: ХУД2020/ДТХ-04-41

Хан-Уул дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь эрх бүхий тендерт оролцогчдоос Хан-Уул дүүргийн 18 дугаар хорооны байрны зоорийн давхрыг тохижуулах барааны тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тул (www.meps.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу. Мөн цахим тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан "Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам"-ын (www.tender.gov.mn) дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50.000 (тавин мянган) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон Туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил /2018, 2019 он/-ийн борлуулалтын дундаж 25.000.000 /хорин таван сая/ төгрөгөөс багагүй байх.

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 1 жил /2019 он/**

Сүүлийн нэг жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: : **Сүүлийн 2 жилийн /2018, 2019 он/ аль нэг жилийн хугацаанд доод тал нь 25.000.000 /хорин таван сая/ төгрөгийн ижил төстэй ажил гүйцэтгэсэн байх, түүнийг нотлох баримт: Ажил гүйцэтгэсэн гэрээ, хүлээлцэн актыг фото зургийн хамт ирүүлэх**

Шаардлагатай тусгай зөвшөөрөл: **Шинэ бол БА-8.1 Хуучин бол 2.1.1 /ба түүнээс дээш/**

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй

Үнийн саналыг **2020 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 11.00 минут**-аас өмнө өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 11.30 минут -т** нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно. Цахим худалдан авах систем (www.tender.gov.mn)-ээс үнэ төлбөргүй татаж авна уу.

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө, Иргэдээд үйлчлэх төв байр, 9 давхарт 902 тоот, утас: 70009011

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
 - 1.1.** Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
 - 1.**
 - 2.** Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1.** Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1.** Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (1) Унийн санал /маягтын дагуу албан бланк дээр бэлтгэсэн байх/ ;
 - (2) Унийн болон нийлүүлэлтийн хуваарь; /гарын үсэг зурж баталгаажулах/
 - (3) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (4) Шаардлагатай тусгай зөвшөөрөл /нотариатаар баталгаажуулсан байх/;
- 4. Тогтмол үнэ**
 - 4.1.** Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Унийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
 - 5.1.** Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2.** Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Унийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 6.1.** Унийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
 - 7.1.** Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
 - 7.2.** Бараа нийлүүлэлтийн хуваарыт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.

- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт																								
ТОӨЗ -1.1 (а)	Захиалагч нь: Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгын газар																								
ТОӨЗ -1.1 (б)	Тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар нь: Хан-Уул дүүргийн 18 дугаар хорооны байрны зоорийн давхрыг тохижуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ХУД2020/ДТХ-04-41																								
ТОӨЗ -1.1 (в)	Тендерт оролцогч “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай”хуулийн 14.1-д заасан нөхцөл байхгүйг бичгээр мэдээлнэ. /албан бланк дээр баталгаажуулж ирүүлнэ/																								
ТОӨЗ -1.1 (г)	Тендерт гарын үсэг зурах этгээдийн гарын үсгийн баталгааг бичгээр гаргах, түүний итгэмжлэл /маягтын дагуу албан бланк дээр баталгаажуулж ирүүлнэ/.																								
ТОӨЗ -1.1 (д)	Хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар. Үйл ажиллагааны чиглэл: Гадаад худалдаа / мөн түншлэлийн гишүүнд хамаарна /																								
ТОӨЗ -1.1 (е)	<p>Тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартайг нотлохын тулд захиалагч дараах нэмэлт нотлох баримтыг тендерийн хамт ирүүлэх:</p> <ul style="list-style-type: none"> - Шүүхийн төрөлжсон архивын тодорхойлолт: /сүүлийн 3 жил хариуцагчаар орж байгаагүй байх./ - Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Тендерт оролцогч татварын тодорхойлолтыг ирүүлэх шаардлагагүй ба www.tender.gov.mn сайтаас нээлт болсон өдрөөр татварын тодорхойлолтыг захиалагч татан авч үзнэ. -Харьяа Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт -Хугацаа хэтэрсэн зээлийн өргүй тухай харилцагч банкны тодорхойлолт. <p>Дээрх тодорхойлолтуудыг тендер зарласан өдрөөс хойш авсан байна.</p>																								
ТОӨЗ -3.1 (1, 2) 7.1	<p>1. Унийн болон бараа нийлүүлэлтийн хуваарь /гарын үсэг зурж баталгаажуулах/</p> <p>2. Тендерт оролцогч нь санал болгосон үнийн дүнд багтаан тухайн ажлыг дуусгаж хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ. Баталгаа гаргаагүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p>																								
ТОӨЗ -3.1 (1)	<p>Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: /1/ 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан. Харьяа дүүргийн Төрийн сангаар баталгаажуулсан байх.</p> <p>Санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулсан байх шаардлагатай эсэх: “шаардлагагүй”.</p>																								
ТОӨЗ -3.1 (3)	<p>Хийж гүйцэтгэсэн ажлын нийт мөнгөн дүнг жил жилээр харуулсан жагсаалт ирүүлэх, шаардлагатай жилийн тоо:</p> <p>Сүүлийн 2 жил / 2018, 2019 он/</p> <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th>№</th> <th>Гэрээний нэр</th> <th>Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо</th> <th>Төсөвт өртөг</th> <th>Дууссан эсвэл дуусах хугацаа</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>2</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td></td> <td>Дүн</td> <td></td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table>					№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо	Төсөвт өртөг	Дууссан эсвэл дуусах хугацаа	1					2						Дүн			
№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо	Төсөвт өртөг	Дууссан эсвэл дуусах хугацаа																					
1																									
2																									
	Дүн																								

ТОӨЗ -3.1 (3)	Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил /2018 он, 2019 он/-ийн дундаж борлуулалт 25.000.000 /хорин таван сая/ төгрөгөөс багагүй байх.																				
ТОӨЗ -3.1 (3)	Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил 2018, 2019 онуудын аль нэг жилд доод тал нь нэг удаа 25.000.000 /хорин таван сая/ төгрөгийн ижил төстэй ажил гүйцэтгэсэн байх, түүнийг нотлох баримт: Ажил гүйцэтгэсэн гэрээ, хүлээлцэн актыг фото зургийн хамт ирүүлэх																				
	<table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Гэрээний нэр</th> <th>Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо</th> <th>Төсөвтөртөг</th> <th>Дууссан эсвэл дуусах хугацаа</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td><td></td><td></td><td></td><td></td></tr> <tr> <td>2</td><td></td><td></td><td></td><td></td></tr> <tr> <td>Дүн</td><td></td><td></td><td></td><td></td></tr> </tbody> </table>	№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо	Төсөвтөртөг	Дууссан эсвэл дуусах хугацаа	1					2					Дүн				
№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо	Төсөвтөртөг	Дууссан эсвэл дуусах хугацаа																	
1																					
2																					
Дүн																					
ТОӨЗ -3.1 (3)	Гэрээг хэрэгжүүлэх удирдах болон инженер, техник, мэргэжлийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл: Гэрээг хэрэгжүүлэх ажилтны /тухайн аж ахуйн нэгжийн үндсэн ажилтан байх/ нийгмийн даатгалын дэвтрин даатгуулагчийн ажил, албан тушаалын өөрчлөлтийн тэмдэглэл, нийгмийн даатгал төлсөн хэсгийн хуулбарыг ирүүлнэ, иргэний үнэмлэхний хуулбар																				
ТОӨЗ -3.1 (4)	Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх: Шинэ бол БА-8.1 Хуучин бол 2.1.1 /ба түүнээс дээш/																				
ТОӨЗ -2.1	<p>Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь:</p> <p>Тендер хүлээн авах этгээд:</p> <p>Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (PDF)-ээр илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 mb, нэг файлын хэмжээ 15 mb байна. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50'000 /тавин мянган/ төгрөгийг www.tender.gov.mn-ээр банкны меркантийн системийг ашиглан төлнө.</p>																				
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: 2020 оны 03 дугаар сарын 26-ны өдөр</p> <p>Цаг: 11 цаг 00 минут</p> <p>Тендер хүлээн авах хугацаа нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p>																				
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, 3 дугаар хороо, Иргэдэд үйлчлэх төв байр, Худалдан авах ажиллагааны алба Давхар болон өрөөний дугаар: 9 давхар 902 тоот өрөө</p> <p>Огноо: 2020 оны 03 дугаар сарын 26-ны өдөр</p> <p>Цаг: 11 цаг 30 минут</p>																				
ТОӨЗ 7.3	<p>Дотоодын давуу эрхийн зөрүү тооцохгүй</p> <p>“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйл, Сангийн сайдын 2007 оны 3 дугаар сарын 30-ний өдрийн 81 дүгээр тушаалын гуравдугаар хавсралтад заасан</p>																				

	<p>“Тендерт оролцогчид давуу эрх олгох аргачлал”-ын дагуу тооцно.” Тендерт оролцогч нь давуу эрх эдлэх хүсэлтэй бол албан хүсэлт ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Монгол Улсын гарал үүсэлтэй бараа, материалыг хамгийн их ашигласан тендерт оролцогч этгээдэд дотоодын давуу эрх олгоно. <ul style="list-style-type: none"> - Тендерт оролцогч нь давуу эрх эдлэх хүсэлтэй бол албан хүсэлт ирүүлнэ. Албан хүсэлтэд: Уг ажилд ашиглах бараа материалын нэрсийн жагсаалт, тоо ширхэг, нэг бүрийн үнэ, нийт үнийг тусгаж өгнө. - Нотлох баримтад: Тухайн бараа материалын тохирлын гэрчилгээ, үйлдвэрлэгчтэй байгуулсан гэрээ /эх хувиар/, -г ирүүлнэ.
--	--

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

БАТЛАВ:
 ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
 ТАМГЫА ГАЗРЫН ДАРГА
 Б.ЭНХБОЛД
 2020 оны 02 сарын 1-ны өдөр

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 18 ДУГААР ХОРООНЫ БАЙРНЫ ЗООРИЙН ДАВХРЫГ
 ТОХИЖУУЛАХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2020 оны 02 дугаар сарын 1.

Улаанбаатар хот

№	Таног төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг	Үзүүлэлт
1	Хивс	1	Эрдэнэт хивстэй дүйцэхүйц. 5x4 хамжээтэй.
2	Хивсанцэр	1	5x4 хамжээтэй.
3	Ханын толь	2	2x2.5 хамжээтэй.
4	Темрен шүүгээ	3	Хамжээ: 1850x900x400 мм Өнгө саарал
5	Бичгийн шүүгээ	2	90 x 185 x 40 см Өнгө саарал
6	Сандал	1	<u>Mater chair 2210H</u> Сандалтай дүйцхүйц Өнгө хар
7	Проектор	1	Няятаршил: SXGA(800x600) Линз: f=17.5 - 29.0mm, F1.7 - 2.1 Лампны чадал / Eco: 180W AC / 145W eco Лампны хугацаа / Eco: 4000цаг / 5000цаг Гаралттай: 3000 ANSI lumens Линзний боссоо шилжилт: +/- 30 градус Ялгаралт: 3000:1 Тусах зайд: 0.6 to 13.8m Утастай сүлжээ LAN: Тийм
8	Ноутбук	1	Үйлдлийн систем / OS: Windows 10 Home Single Language (64bit) Процессор / CPU: 8th Generation Intel® Core™ i3-7020U Processor (3MB Cache, 2.3GHz) Шуурхай санах ой / RAM: 4GB, 2666MHz, DDR4; up to 16GB (additional memory sold separately) Далалц: 15.6-inch HD (1366 x 768) Anti-Glare LED-Backlit Non-touch Display График: Intel® HD Graphics 620 with shared graphics memory Багтамж / SSD+HDD: 1TB 5400 rpm 2.5" SATA Hard Drive CD/DVD уншигч: Tray load DVD Drive (Reads and Writes to DVD/CD) Интерфэйс: 1 x SD card

			<p>1 x USB 2.0 1 x Optical Disk Drive 1 x Wedge-shaped lock slot 1 x Power 1 x HDMI 1.4b 1 x RJ45 2 x USB 3.1 Gen 1 1 x Headphone & Microphone Audio Jack Камер / Микрофон: Integrated widescreen HD (720p) Webcam with Single Digital Microphone Wireless / Улаасгүй сүлжээ: Qualcomm DW1810 1x1 802.11ac Wi-Fi Wireless LAN and Bluetooth 4.1 Speaker: 2 tuned speakers with Waves MaxxAudio® Pro Power: 45 Watt AC Adapter (with standard graphics) Баттерий: 3-Cell 42WHR Battery (Integrated)</p>
9	Компьютер линк бүрэн/	1	<p>Процессор / CPU: Intel® Core i7 6700 2.7GHz Turbo boost up 3.3GHz Шуурхай санах ой / RAM: 8GB DDR4 SDRAM 2133MHz Хаттуу диск / HDD: 1TB 7200 rpm SATA 6Gb/s Hard Drive Оптик драйв: DVD±RW (±R DL) / DVD-RAM - SATA Оролт гаралтууд: 4 x USB 2.0 2 x USB 3.0 Audio line-out Audio line-in 1 x LAN (Gigabit Ethernet) 1 x VGA 1 x DVI 220 Watt Power Supply Далгац: 21.5" LED Display Нэгтрэл: 1920 x 1080 at 60 Hz Контраст: 1000:1 (typical) Response Time: 5 ms Оролт: VGA Харагдах өнцөг (боссоо/хавтаз): 160/170 градус Хэмжээ (суурьтай): 396.7 mm x 512.2 mm x 180.0 mm Дагалдах харигсал: Keyboard Mouse Speaker Өнгө: Хар</p>
10	Принтер	1	<p>Функци: Жавлаж, хувилаж, сканнер Жавлаж хурд: 23 хуудас хуртлал (хар) Жавлаж, хувилаж нэгтрэл: 600 x 600dpi Сканнер нэгтрэл: 1200 x 1200dpi Далгац: 2-Line LCD Холболтууд: Hi-Speed USB 2.0, Wi-Fi 802.11b/g/n, 10/100Base-TX Network port, Phone line port (in/out) Санах ой - 256 MB Тохиорх хор: HP 17A (CF217A) дунджаар 1600 A4 хуудас</p>

			Хэмжээс: 76 x 127 to 216 x 356 mm
11	Баллонгийн ус шүүгч	1	Ус буцалгах болон хөргөх гаримтой байна.
12	Шатар	5	35x35 см-аас доошгүй хэмжээтэй. Модон материалытай.
13	Дазм	5	Соронзтой дэам байна.
14	Проекторийн дэлгэц /бүудаг/	1	<u>VEGA Screen Motor /</u> <ul style="list-style-type: none"> • Хананаас втгедэг • Автомат (мотортой) • Хэмжээ (Өндөр x Өргөн): 90x120 инч / 228 x 304 см
15	Проекторийн дэлгэц/хөлтэй	1	<u>VEGA Screen Tripod /</u> <ol style="list-style-type: none"> 1. Зөвверлэхэд тохиromжтой звхагддаг 2. Хэмжээ (Өндөр x Өргөн): 72x96 инч / 182 x 243 см
16	Дартс	2	Хананд тогтоодог самбар, сум бүхий иж буран дартс.
17	Файлын шүүгээ	2	3. 185*90*40 см 4. Онгте саарал
18	Спикер	1	<ul style="list-style-type: none"> • Дууны гаралт: 1ch • Чадал: 40ватт • Хуралтээр мэдэрдэг удирдлалын хэсгэйтэй • Төгөх формат: MP3/ AAC/ WAV/ FLAC/ ALAC • Ухаалаг холболтын технологитой • Wireless LAN • Wi-Fi Frequency Range (5GHz/ 2.4GHz) • Ethernet (10 Base-T/ 100 Base-TX) • WPS дэмждаг • Wireless Audio with DLNA • Bluetooth® Wireless • Panasonic Music Streaming App*3 yes*3 • Re-streaming (Bluetooth®, AUX) • Stereo Paring • Холболт (AUX) /3.5 mm Jack • LAN 100 Base-TX • Цаг, Сэргүүлэгтэй
19	Өслгэч /чанг/	2	<ul style="list-style-type: none"> • Дугаралт: Full Range Satellite Speaker 2.40" with Super ExtraBASS • Утасгүй холбогт: NFC, Bluetooth 4.2 • Hands-FREE Function: Yes • Bluetooth холбогт: Холбогдох зай -10м, дэмжих codec-SBC / AAC / LDAC, Давтамж-2.45GHz • Даавтамж: 40 Hz-20.000 Hz • Интерфэйс: USB A, Stereo Mini Jack IN • Баттерей: 24 цаг барих дахин цэнэгээдэг батеритай • Усны хамгаалалт: IPX5 (Splash Resistant)
20	Микрофон	2	Еренхий үзүүлэлт: Утасгүй/ Analog or digital: Digital Frequency response: 50Hz – 15kHz Dynamic range: 100 dB Ажиллах радиус : 300 ft, 100м Polar pattern: Cardioid

			<p>Баттерей: AA x 2 Хүлээн авагч: Channels: 12 Bandwidth: 524 – 865 MHz Housing: Not specified Rackmountable: No</p>
21	Олон залгуур	4	4-осс доошгүй залгуурын оролттой. Бат бөх материалтай залгуур.
22	Хөгийн сав	2	Бат бөх хуванцар материалаар хийгдсан байна.
23	Төхөөрөмж	1	1800 ваттын хүчин чадалтай, цассан ууттай, 3.5л багтаамжтай.
24	Дууны пульт	1	12-осс дээш замтай, 350 вт Mixer /YAMAHA/-тай дүйцэхүйц.
25	Даралтны аппарат	1	<p>Хэмжилтийн хязгаар:</p> <ul style="list-style-type: none"> • Даралт: 0-280 mmHg • Цохилт: 40–180pulse/min <p>Нарийччлал:</p> <ul style="list-style-type: none"> • Даралт: ±3mmHg • Цохилт: ±5% <p>Овор хэмжээ: 66,5x44,5x161,5мм</p> <p>Цахилгавн хүчдэл: DC 1.5V 2ш</p>
26	Телевизор-60инч	1	<p>Далгацийн хэмжээ: 60инч Функци: Энгийн Далгацийн нягтаршил: 1920 x 1080 FullHD Халбар: Хавтгай Далгацийн төрөл: LED Өнгө: Хар Дууны систем Dolby Audio</p>
27	Хүлээн авах ширээ	1	180x65x105см хэмжээтэй. Төвцэн: Модны үргэлж шахмал Хөл: Темпер
28	Сургалтын ширээ	10	120x60x75см хэмжээтэй. Төвцэн: Модны үргэлж шахмал Хөл: Темпер
29	Сандал	50	Темпер суурьтай, хар савхин материалтай.
30	Хөлөгт тоглоом	2	Саяган хөлөгт тоглоомтой дүйцэхүйц.
31	Самбар	1	Цагаан ногсоон 2 талтай хөлтэй самбар 90x180 хэмжээтэй. Шохой, маркер, зрилгэгчийн хамт.
32	Печь	1	23 литр багтаамжтай 1150 W хүчин чадалтай 48 x 27 x 35см хэмжээтэй Керамик дотортой, меканик тохируулгатай
33	Хувцасны өлгүүр /түтлийн тавиур/	1	Хувцасны өлгүүр 10- эвс доошгүй, гутлын тавиур 10эвс доошгүй багтаамжтай, модон шахмал материалтай, өлгүүр нь бат бөх темиреэр хийгдсон байна.

34	Өрөө хөорондын модсон хаалга	3	Дуу чимээ тусгаварлах жийргэвч рөзинтэй Ханын зузанд нь тохирсон амалгааны хацар мөдтэй Технологийн дагуу хатаасан наар мөдсөр хийгдсан Үүр ус, хэв тажилтвас хамгаалсан хамгаалалтын лакан бүрхүүлтэй Стандартын шаардлагад нийцсэн нутгас цоожтой Дулзаан дамжуулалтын засргүүцэл нь MNS 4194:93 стандартыг хангасан Чанар ба экологид хор наалеегүй Герман стандартад нийцсэн Хөнгөн цагаан бариуп Түүлхүүртэй голтой цюж /PZ/
35	Бүргэд хаалга	2	Өнгө хувирахгүй авто будагтай төмөр хаалга.
36	Иргэний танхим хаяг	1	Төрийн байгууллагын хаяжилтийн стандартын дагуу хийгдсан байх.

1. Техник, тоног төхөөрөмжийг ашиглах ном, гарын авлагачаар хангах
2. Нийлүүлсэн техник, тоног төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг шалгасны дараа хүлээлгэн авах
3. Нийтгүүлсэн тавилга, хэрэгслийг угсарч, сууринуулан хүлээлгэн авах
4. Тухайн зоорийн давхрын хана, таазыг будаж, саргээх ажлыг хийж гүйцэтгэнэ.

Баталгаа:

Баразны 1 жилийн баталгааны хуудастай байх

Баталгаат хугацаанд эвдрэл, гэмтэл гарсан тохиолдолд засвар үйлчилгээг шуурхай хийх

ХЯНАСАН:

ЭДИЙН ЗАСАГ, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ОТГОНБАЯР

18 ДУГААР ХОРООНЫ
ЗАСАГ ДАРГА

Д.ЭНХЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН:

ЭДИЙН ЗАСАГ, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

З.Намуун У.НАМУУН

- Стандарт:** Нийлүүлэгдэх бараа нь Монгол улсад мөрдөгдөж байгаа болон олон улсын стандартын шаардлагыг бүрэн хангасан, гарал үүсэл, үйлдвэрлэгч нь тодорхойлолтыг тендерийн баримт бичигт загварыг хавсаргаж ирүүлнэ.
- Баглаа, боодол:** Нийлүүлэгч барааг эцсийн цэг хүртэл тээвэрлэх явцад эвдрэх гэмтэхээс урьдчилан сэргийлэх баглаа боодлоор хангана. Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн хатуу нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн болон давс, хур тундас зэргийг хангалттай тэсвэрлэхээр байна.
- Бараа хүргэх газар:** Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө, Иргэдэд үйлчлэх төв байр

4. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

БАРААНЫ ЖАГСААЛТ БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Тоног төхөөрөмжийн нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжи х нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермиин нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Техникийн тодорхой лолтод заагдсан бараа, ажил	Шаардлагад нийцсэн	Техникийн тодорхойл олтод заагдсан бараа, ажил	iii	Хан-Уул дүүргийн 18 дугаар хорооны байр	Гэрээ байгуулагданаас хойши 7 хоногт	Гэрээ байгуула гдсанаас хойши 14 хоногт	

Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [моо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаarahгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

1. ИТГЭМЖЛЭГДСЭН БИЧИГ

Энэхүү тендерийн бичиг баримтад гарын үсэг зурагч _____
Компанийн _____ ажилтай _____ овогтой _____ нь _____ компанийн нэрийн өмнөөс
үйл ажиллагаа явуулах хууль ёсны итгэмжлэгдсэн төлөөлөгч мөн тул _____ овогтой _____ ын
дор зурсан гарын үсгийг баталгаажуулж байна.

_____ овогтой _____ нь _____ компанийг төлөөлж _____ компанийн нэр
дээр гэрээ, хэлцэл байгуулах, ажил эхэлж дуусгах, гүйцэтгэл гаргах, гологдлыг барагдуулах, албан
бичиг баримт явуулах зэрэг сонгон шалгаруулалтад холбогдолтой бүх материалд гарын үсэг зурах
эрхтэй болно.

Энэхүү итгэмжлэх бичгийг гэрчилж 2020 оны __ дугаар сарын __ ны өдөр гарын үсэг зурав.

Тэмдэг

Байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн
Овог, нэр _____
Гарын үсэг _____

Баталгаажуулагчийн
Овог, нэр _____
Гарын үсэг _____

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших	1.1.	Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт	2.1.	Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх	3.1.	Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх	4.1.	Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа	5.1.	Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [1] жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах	6.1.	Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр	7.1.	Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ажлын 7 хоног] хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь	8.1.	Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах	9.1.	Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах	10.1.	Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх	11.1.	Талууд гэрээний үүргийн биелэлтэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.
12.		
13.		

14.

15.

16.

17.

18.

19.

20.

21.

22.

23.

24.

25.

26.

27.

28.

29.

30.

31.

32.

33.

34.

35.

36.

37.

38.

39.

40.

41.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|--|
| <p>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</p> | <p>1.1. Барааг комисс шалгаж хүлээн авах ба шаардлагатай бол үйл ажиллагааны туршилтуудыг хийнэ. Нийлүүлэгч нь захиалагчид шалгуулж хүлээлгэн өгнө.</p> |
| <p>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</p> | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ol style="list-style-type: none">1) Нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;2) Барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;3) Барааны гарал үүслийн гэрчилгээ. |
| | <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| <p>3. Баталгаат засвар (ГЕН-5)</p> | <p>5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.</p> <p>Нийлүүлэгч нийлүүлсэн тоног төхөөрөмждөө 1 жил хугацаанд баталгаат хугацаа өгөх ба баталгаат засварын хугацаанд үйлдвэрийн гэмтлийг хариуцна. Тоног төхөөрөмжийн ажиллах зааврын талаар захиалагчид <i>[Монгол хэл]</i> дээр орчуулсан гарын авлага гаргаж өгнө.</p> |
| <p>4. Төлбөр (ГЕН – 7)</p> | <p>7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:</p> <p>Гэрээний үнийн дүнгийн 100 хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.</p> |
| <p>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)</p> | <p>9.1. Алданги оногдуулах хувь: Хууль болон гэрээнд заасан хугацаа хэтрүүлсэн тал нь хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр төлөхөөр тогтоосон алдангийг төлнө.</p> |
| <p>6. Чанарын баталгаа</p> | <p>Алдангийн нийт дүн: Нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 хувиас хэтэрч болохгүй</p> <p>6.1. Чанарын баталгаа нь гэрээний үнийн <i>[5 хувь]-иас доошгүй дүнтэй байна.</i></p> |

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № *[Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]*

..... хот/аймаг

Нэг талаас *[захиалагчийн нэр]* (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас *[нийлүүлэгчийн нэр]* (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь *[гэрээний нэр, дугаар]-г* (цаашид “бараа” гэх) *[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]* (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт түйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны ____ дугаар сарын ____-наас _____ оны ____ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дунг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]